

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр  
Тендер дугаар: МРЦМ/202107654

“Монголросцветмет” ТӨҮГазар нь хөгжлийн бодлогын төлөвлөгөөний хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын нутагт ашиглагдаж төмрийн хүдрийн орд болон Бор-Өндөр УБҮ-ийн төмрийн хүдрийн баяжуулалтын бүтээгдэхүүнийг ашиглан боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинээр байгуулагдах хар металлургийн үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор “Төмрийн хүдрийн хорголжингийн үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх тухай санал ирүүлэхийг урьж байна.

Энхүү зөвлөх үйлчилгээ нь уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах, шинээр байгуулагдах хар металлургийн үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх орон нутагт шинээр ажлын байр бий болгоход чиглэгдэнэ.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн ӨХБАҮХАТухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан болон үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааны танилцуулга
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээ
- Тухайн зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх, уул уурхай, үйлдвэрлэлийн зураг, төсөл боловсруулах чадвартай боловсон хүчинтэй байх
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2019, 2020 (Сүүлийн хоёр жилд заагдсан зөвлөх үйлчилгээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Уул уурхай, үйлдвэрлэлийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл
- Уул уурхай, үйлдвэрлэлийн зураг, төсөл боловсруулах ажлын 3 жилээс багагүй туршлагатай байх

Сонирхсон хуулийн этгээд тендерийн тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг **Захиалагч [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.**

Сонирхсон хуулийн этгээд мэдүүлгээ **2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.**

**“Монголросцветмет” ТӨҮГ**